



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/09/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2024 он

Дарга,
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506 Цахим хаяг: BoldbaatarH@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 90088028 Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Уластай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-36-12

И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.03.15 № 243

танай

-ны №

-т

"АМЬ-УС" ХХК ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.МЯГМАРДОРЖ-д

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Амь-Ус" ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол "Амь-Ус" ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны 30.5 сая төгрөгийн айл өрхийн борлуулалтын орлогыг хугацаанд нь төвлөрүүлээгүй, он дамжсан 19.1 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй, орлогын байцаагч нар бэлнээр хүлээн авсан 8.1 сая төгрөгийн орлогыг журамд заасан хугацаанд харилцах дансанд төвлөрүүлээгүй, 7.8 сая төгрөгийн борлуулалтын орлогыг бэлнээр хүлээн авч, шууд зарцуулсан, 2.4 сая төгрөгийн албан томилолтын зардлыг олгохдоо холбогдох журмыг мөрдөөгүй, 0.5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тайлагнаагүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам", Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаалаар батлагдсан "Албан томилолтын

Audit(D)Дүгнэлт/2024

0130 0425

зардлын тариф шинэчлэн батлах тухай" журам зэрэгтэй нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

"Амь-Ус" ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгж нь тайлант оны эхэнд цэвэр, бохир усны үнэ тарифыг Усны зохицуулах зөвлөлөөр шинэчлэн батлуулж мөрдсөн. Тайлант онд 1,314.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,256.1 сая төгрөгийн зардал гарган, 58.7 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

Бусад асуудлын хэсэг

"Амь-Ус" ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгж нь тайлант онд 517.9 мянган м³ цэвэр усыг газрын гүнээс цахилгаанаар татан авч түгээснээс 307.9 мянган м³ цэвэр усыг худалдан борлуулж, 210.7 мянган м³ цэвэр усыг худалдан борлуулж чадалгүй усны алдагдлаар бүртгэжээ. Усны нийт алдагдлаас зөвшөөрөгдөх хэмжээг хассанаар 198.1 мянган м³ усны алдагдлын шалтгааныг тогтоож чадаагүй байгаа бөгөөд энэ нь оноос 2.5 дахин өссөн байгааг бууруулж ажиллах зөвлөмжийг аудитаас хүргүүлсэн.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 01-р сарын 01	2023 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	26,753.1	57,737.14
1.1.2	Дансны авлага	51,476.9	153,315.99
1.1.6	Бараа материал	165,509.1	219,336.93
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	243,739.1	430,390.06
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,362,478.4	1,317,300.56
1.2.2	Биет бус хөрөнгө	6,120.0	4,680.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,368,598.4	1,321,980.56
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,612,337.6	1,752,370.62
2.1	ӨР ТӨЛБӨР	1,344,825.7	1,380,742.22
2.1.1.1	Дансны өглөг		21,285.67
2.1.1.3	Татварын өр	36,775.1	51,406.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	3,604.9	3,604.94
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	40,380.1	76,296.61
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,304,445.6	1,304,445.61
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,304,445.6	1,304,445.61
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,344,825.7	1,380,742.22
2.3.1	Өмч: - төрийн	310,884.6	307,074.97
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	202,588.0	202,588.04
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	603,406.5	603,406.51
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	27,805.1	78,205.06
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(881,717.2)	-819,646.18
2.3.10	Тайлант үеийн үр дүн	4,544.9	58,695.69
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	267,511.9	371,628.39
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	1,612,337.6	1,752,370.62

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/мянган төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,004,120.8	1,197,679.9
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	833,984.6	908,965.6
3	Нийт ашиг (алдагдал)	170,136.2	288,714.3

8	Бусад орлого	0.00	117,096.5
10	Ерөнхий ба удирдлагын зардал	163,460.4	340,593.4
11	Санхүүгийн зардал	1,626.0	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	5,049.9	65,217.4
19	Орлогын татварын зардал	505.0	6,521.7
20	Татварын дараах ашиг (алдагдал)	4,544.9	58,695.7
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	4,544.9	58,695.7
24	Орлогын нийт дүн	4,544.9	58,695.7

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
Залруулсан үлдэгдэл	310,884.6	202,588.0	603,406.5	27,805.1	(881,717.2)	262,967.0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	4,544.9	4,544.9
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-	-
2023 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	310,884.6	202,588.0	603,406.5	27,805.1	(877,172.4)	267,511.9
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				50,400.0	1,169.5	49,230.5
Өмчид гарсан өөрчлөлт	3,809.66					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	58,695.69	58,695.69
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	310,884.6	202,588.0	603,406.5	78,205.1	(819,646.18)	371,628.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,162,907.7	1,343,458.89
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,058,839.2	1,200,896.01

	Бусад мөнгөн орлого	104,068.6	142,476.13
1.2	Мөнгөн зарлага (-)	1,114,178.6	1,292,974.80
	Ажиллагчдад төлсөн	393,761.6	484,766.97
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	112,348.4	143,902.19
	Бараа материал худалдан авахад төлсөн	231,811.1	244,277.83
	Ашиглалтын зардалд төлсөн	148,938.6	150,924.20
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	90,207.9	95,586.33
	Татварын байгууллагад төлсөн	113,291.9	123,820.37
	Даатгалын төлбөрт төлсөн	871.6	935.55
	Бусад мөнгөн зарлага	22,947.5	48,761.36
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	48,729.2	50,484.09
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	237,441.7	19,500.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	229,521.7	19,500.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,920.0	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(237,441.7)	(19,500.0)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	209,556.8	30,984.09
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,908.8	26,753.1
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	215,465.6	57,737.14

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр

Д/Д	Үзүүлэлт	2023 оны төлөвлөгөө	2023 оны гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин	567,115	581,627.68	(14,512.68)
2	НДШ	70,889	78,021.73	(7,132.73)
3	Цахилгаан	144,000	112,490.41	31,509.59
4	Шатахууны зардал	56,000	69,401.63	(13,401.63)
5	Түлээ нүүрс	10,500	5,956.55	4,543.45
6	Түүхий эд материалын зардал	76,000	164,165.32	(88,165.32)
7	Сэлбэг хэрэгсэл	15,000	5,204.76	9,795.24
8	Хөдөлмөр хамгаалал	16,500	1,904.64	14,595.36
9	ҮХ элэгдэл	91,000	111,526.31	20,526.31
10	Албан томилолт	8,000	10,867.9	(2,867.9)
11	Холбоо бичиг хэрэг/ ашиглалтын зардал	7,500	5,616.93	1,883.07
12	Тээврийн зардал	3,500	3,720.55	(220.55)
13	Зар сурталчилгаа	500		500
14	Шагнал урамшуулал	5,500	1,260	4,240
15	Тэтгэмж	19,500	9,327.26	10,172.74
16	Сургалт семинар	3,500	3,915.5	(415.5)
17	Найдваргүй авлагын зардал	1,000		1,000
18	Татварын зардал	6,500	1,417.3	5,082.67
19	Интернэтийн зардал	5,000	6,156.55	(1,156.55)
20	Засвар үйлчилгээ	20,000	3,511.86	16,488.14
21	ТУЗ-ийн зардал	3,000		3,000

22	Ажлын хөлс	9,000	6,322.09	2,677.91
23	Усны шинжилгээ	1,500	1,316.4	183.6
24	Бусад зардал	25,000	8,304.59	16,695.41
25	халаалт	36,000	39,522.59	3,522.59
26	даатгал	1,500	934.5	565.5
27	Ариун цэвэр, лабораторийн зардал	3,000		3,000
28	усны зохицуулах зөвлөл	6,500	4,995.8	1,504.2
29	Эрүүл мэндийн үзлэг	2,500		2,500.0
30	Баруун аймгуудын мэргэжил туршлага солилцох уулзалтын зардал	8,000	5,000	3,000.0
31	Урсгал засвар	10,000	7,070.15	2,929.85
32	Гадна орчин ногоон байгууламж мод тарих	1,000.0		1,000.0
дүн	Нийт дүн	1,234,504	1,249,559	15,055

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

“Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн зорилго: Хэрэглэгчдийг унд ахуйн стандарт, шаардлагад нийцсэн усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, байгаль экологид нөлөөлөлгүйгээр цэвэршүүлэх, инженерийн байгууламжийн тасралтгүй найдвартай үйл ажиллагааг хангаж, хэрэглэгчдийг тав тухтай орчинд амьдруулах, гарсан аваар ослыг шуурхай арилгах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

“Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:

- Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ,
- Тоолуур суурилуулах, худалдах үйлчилгээ

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

“Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Усны тухай хууль
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Тайлант хугацаанд “Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

“Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж,

гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2008 онд батлагдсан бөгөөд шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140,033.0 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	26,753.0	57,737.1	30,984.1
Авлага	51,477.0	153,316.0	101,839.0
Бараа материал	165,509.1	219,336.9	53,827.8
Үндсэн хөрөнгө	1,368,598.4	1,321,980.6	-46,617.8
Нийт хөрөнгө	1,612,337.6	1,752,370.6	140,033.0
Өр төлбөр	1,344,825.7	1,380,742.2	35,916.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	267,511.9	371,628.4	104,116.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,612,337.6	1,752,370.6	140,033.0

Тус компани нь Хаан банк, Төрийн банк, Хас банканд тус тус төгрөгийн харилцах данстай, бэлэн мөнгөний кассаар мөнгөн хөрөнгө зарцуулдаг. Тайлант оны эцэст банкны харилцах дансны үлдэгдэл 55,369.8 мянган төгрөг, бэлэн мөнгөний кассын үлдэгдэл 2,367.4 мянган төгрөг болж өмнөх оноос 30,984.1 мянган төгрөгөөр өссөн нь борлуулалтын орлого өссөн, нягтлан бодогч чөлөөтэй байснаас шалтгаалан өглөгөө төлөөгүй зэрэгтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 101,839.0 мянган төгрөгөөр өссөн нь цэвэр усны үнэ тариф нэмэгдсэн, орлогын байцаагч нар тайлант онд 2-3 удаа солигдон айл өрхийн борлуулалтын авлага өссөн зэрэгтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 53,827.8 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл дансны үлдэгдэл 46,617.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлуудтай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 35,916.5 мянган төгрөгөөр өссөн нь татварын байгууллагатай холбоотой өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 104,116.5 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дансны өсөлттэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

“Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгж нь 2023 оны орлого, зарлагын саналд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг өөрийн орлогоос 1,237.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,234.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгж нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө/-г боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 1,237,450.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,234,504.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,314,776.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,256,080.7 мянган төгрөгийн зардал гарган, 58.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,314,776.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 77,326.4 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,256,080.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 21,576.7 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар хэтэрсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд “Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгж түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2023 оны санхүүгийн тайлангаа Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт мөнгөн зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт мөнгөн зардлын 1,312,474.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,124.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн шилэн дансны мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой 18,330.7 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	641.5	2	641.5	100%
Албан шаардлага	1	1,837.5	1	1,837.5	100%
Зөвлөмж	1	1,139,577.7	1	1,139,577.7	100%
Нийт дүн	4	1,142,056.7	4	1,142,056.7	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын хөдөлгөөний бүртгэл, ерөнхий журналын хөтлөлт, баримтжуулалтыг анхаарах шаардлагатай

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 236,373.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 167,961.8 мянган төгрөгийн зөрчлийг залруулан, 68,412.0 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргуулахгүйн тулд зөвлөмж өглөө. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд авлага, өглөг, бараа материалын дүнг 899.1 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд орлого, зардлын дүнг 148,537.7 мянган төгрөгөөр, үр дүнгийн тайланд орлого, зардлын дүнг 18,525.1 мянган төгрөгөөр буруу илэрхийлснийг тус тус залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчил илрээгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Орлогын байцаагч нар солигдсоноос шалтгаалан тайлант оны 30,509.7 мянган төгрөгийн айл өрхийн борлуулалтын орлогыг хугацаанд нь төвлөрүүлээгүй байна.
2. Он дамжсан 19,076.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй байна.
3. Тайлант онд 517.9 мянган м3 цэвэр усыг газрын гүнээс цахилгаанаар татан авч түгээснээс 307.9 мянган м3 цэвэр усыг худалдан борлуулж, 210.7 мянган цэвэр усыг худалдан борлуулж чадалгүй усны алдагдлаар бүртгэжээ. Усны нийт алдагдлаас зөвшөөрөгдөх хэмжээг хассанаар 198.1 мянган м3 усны алдагдлын шалтгааныг тогтоож чадаагүй байгаа бөгөөд энэ нь оноос 2.5 дахин өссөн байна.

Өгсөн зөвлөмж:

1. Айл өрхийн борлуулалтын орлогыг төвлөрүүлэхдээ цахим технологийн дэвшлийг ашиглах, айл өрхийг ухаалаг тоолуураар хангах бодлогыг боловсруулан, санхүүжилтийг аймгийн ИТХ-аар батлуулах, айл өрхийн авлагын үлдэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулах
2. Он дамжсан авлагын үлдэгдлийг барагдуулах ажлыг зохион байгуулах, барагдуулаагүй тохиолдолд хуулийн байгууллагад хандах
 1. Газрын гүнд алдагдаж байгаа усны байршлыг тогтоон бууруулах арга хэмжээ авч ажиллах үүргийг ус сувгийн инженер, сантехникийн ажилтнуудад өгч биелэлтийг тооцох

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Орлогын байцаагч нар бэлнээр хүлээн авсан 8,088.3 мянган төгрөгийн орлогыг журамд заасан хугацаанд харилцах дансанд төвлөрүүлээгүй, эд хариуцагч 7,791.5 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг бэлнээр хүлээн авч, шууд зарцуулсан зэрэг

нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.6.10-д “Байгууллага нь мөнгөн касстаа бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан харилцах банк дахь бүртгэлийн дансанд тушаана” гэж заасныг зөрчсөн байна.

2. Нэр бүхий ажилтнуудад 2,450.9 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг дутуу тооцож олгосон нь Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаалаар батлагдсан “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” журмыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

1. Борлуулалтын орлогыг кассад төвлөрүүлэн шууд зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох, орлогын байцаагч нарт борлуулалтын орлогыг бэлнээр хураахгүй байх чиглэлийг өгч, хураасан тохиолдолд Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан хугацаанд харилцах дансанд төвлөрүүлж хэвших үүрэг өгч биелэлтийг тооцох
2. Албан томилолтын зардлыг олгохдоо Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаалаар батлагдсан “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” журмыг мөрдөх

3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийг 495.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
2. Санхүүгийн ажилтнуудыг сургах, бэлтгэх бодлого алдагдсанаас санхүүгийн тайлан баталгаажуулахад их хугацаа зарцуулагдсан. Аудитаар ажилтнуудын ажлын ачаалал харилцан адилгүй, ажлын уялдаа холбоо муутай байдал ажиглагдсан.

Өгсөн зөвлөмж:

1. Нийгмийн даатгалын газарт шимтгэлийн тайланг залруулах хүсэлт өгч дутуу тайлагнасан зөрчлийг арилгах
2. Санхүүгийн ажилтнуудыг сургах, дадлагажуулах ажлын ачааллыг тэнцүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх, борлуулалтын программ худалдан авч санхүүгийн бүртгэлдээ ашиглах, орлогын байцаагч нар, дуудлагын сантехникч, инженер нарын ажлыг уялдуулах

4. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Шинээр томилогдсон лабораторийн ажилтан нь бохир усны шинжилгээг хийх, цэвэр усны шинжилгээг зэрэгцээ аргаар гүйцэтгэх, СХЗХ-ийн химийн лабораторийн шинжилгээний үр дүнтэй өөрийн лабораторийн үр дүнг харьцуулах, илт зөрүүтэй тохиолдолд СХЗХ-ийн химийн лабораторид мэдэгдэж, зөрүүг арилгах зэрэгт суралцаагүй байна. Мөн лабораторийн өрөө нь химийн бодис бүхий агаарыг сорох зориулалттай шүүгээгээр хангагдаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. Лабораторийн ажилтан нь бохир усны шинжилгээг хийх, цэвэр усны шинжилгээг зэрэгцээ аргаар гүйцэтгэх, СХЗХ-ийн лабораторийн шинжилгээний үр дүнтэй

өөрийн лабораторийн үр дүнг харьцуулах, зөрүү илэрсэн т үүргүүдийг өгч биелэлтийг тооцох

- Лабораторийн өрөөг химийн бодис бүхий агаарыг сорох зориулалттай шүүгээгээр хангах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын тайланг алдаатай илэрхийлсэн	1	899.1			1	899.1	1	899.1				
Мөнгөн гүйлгээний тайланг алдаатай илэрхийлсэн	1	148,537.7			1	148,537.7	1	148,537.7				
Үр дүнгийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	18,525.1			1	18,525.1	1	18,525.1				
Дүн	3	167,961.8			3	167,961.8	3	167,961.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
тайлант оны айл өрхийн борлуулалтын орлогыг хугацаанд нь төвлөрүүлээгүй	1	30,509.7					1	30,509.7					
нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тайлагнаагүй байна.	1	495.5					1	495.5					
Он дамжсан авлагын үлдэгдлийг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй байн	1	19,076.1					1	19,076.1					
Усны алдагдлыг бууруулах бодлого баримтлаагүй байх	1	0					1	0					
СХЗХ-ийн химийн лабораторийн усны шинжилгээний үр дүн нь	1						1						

Амь-Ус лабораторийн шинжилгээний дүнгээс зөрсөн байх	ХХК-ийн үр													
Дүн	5	50,081.3					5	50,081.3						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
албан томилолтын зардлыг олгохдоо холбогдох журмыг мөрдөөгүй.	1	2,450.9					1	2450.9
борлуулалтын орлогыг бэлнээр хүлээн авч, шууд зарцуулсан байна	1	7,791.5					1	7,791.5
Орлогын байцаагч нар бэлнээр хүлээн авсан орлогыг журамд заасан хугацаанд харилцах дансанд төвлөрүүлээгүй.	1	8,088.3					1	8,088.3
Лабораторийн ажилтны ур чадвар болон ажиллах нөхцөлийг сайжруулах бодлого баримтлаагүй байх	1						1	
Дүн	4	18,330.7					4	18,330.7

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР



Д.БАТ-УНДРАА



Г.ЗАЯА

Огноо: 2024-03-15



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ
ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ОРОСОО-Д

2024-03-25 № 265
танай _____ -ны № _____ -т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтад тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар танай байгууллагын химийн лабораторитой холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын итгэмжлэгдсэн химийн лабораторийн 2023 оны усны шинжилгээний үр дүн нь “Амь-Ус” ХХК-ийн дотоод лабораторийн шинжилгээний үр дүнгээс илт зөрүүтэй байсан, зарим усны химийн шинжилгээг хугацаа хоцроон гүйцэтгэсэн байна.

Дээрх зөрчил нь Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025 : 2018 стандартын 4.1.3-д “Лаборатори нь өөрийн үйл ажиллагааныхаа шударга байдлыг хариуцах ба худалдаа, санхүүгийн, эсвэл шударга байдалд заналхийлэх аливаа ажиллагааг явуулахгүй”, 4.1.4-д “Лаборатори нь өөрийн шударга байдалд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлдог байна. Үүнд өөрийн үйл ажиллагаанаас, эсвэл түүний харилцаа, эсвэл ажилтнуудын хоорондын харилцаанаас үүсэх эрсдэлийг багтаана. Гэхдээ ийм харилцаа нь лабораторийн шударга байдалд эрсдэл учруулахгүй байна”, 5.4-д “Лаборатори нь энэхүү стандарт болон лабораторийн үйлчилгээг хэрэглэгч, зохицуулагч эрх бүхий байгууллага, хүлээн зөвшөөрдөг байгууллагын шаардлагыг хангаж, үйл ажиллагаагаа явуулна. Үүнд: лабораторийн байнгын байгууламж дээр, түүний байнгын байгууламжаас хол орших газарт, холбогдох түр буюу явуулын байгууламж дээр, хэрэглэгчийн байранд хийгдэх лабораторийн бүх үйл ажиллагаа хамарна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд уг зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүйн тулд доорх зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Химийн лабораторид илэрсэн үл тохирлын шалтгааныг олж, залруулах
2. Химийн шинжилгээг хугацаа хоцроон гүйцэтгэдэг зөрчлийг арилгах
3. Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандартыг мөрдөж ажиллан, улиралд 1 удаа лабораторийн дотоод болон лаборатори хоорондын харьцуулалтыг гүйцэтгэн, харьцуулалтдаа “Амь-Ус” ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн хяналтын лабораторийг оролцуулж хэвших.

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 07 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА